# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 31 өдөр Дугаар А/672 Арвайхээр

Отрын штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “а” заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд 2019-2020 оны өвөл, хавар өөрийн аймгийн сум хооронд болон зэргэлдээ аймгийн нутагт отроор өвөлжиж байгаа малчдад эрүүл, мэнд, нийгэм, төрийн үйлчилгээг зохицуулах “Аймгийн отрын штаб”-ыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаар холбогдох судалгаа, мэдээллийг нарийвчлан гаргаж, малчдын сургуулийн насны хүүхдийг тухайн очсон сумдын сургуульд хамруулах, хүн, мал эмнэлэг, соёл, холбоо мэдээлэл, төрийн үйлчилгээгээр үйлчлэх асуудлыг сумдын удирдлагуудтай хамтран зохицуулж, малчдыг тав тухтай өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээ авч ажиллахыг “Аймгийн отрын штаб” (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011101269

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | өвчин гарсан тохиолдолд тухайн сумын Засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах | | | | |
| 6. | Отрын малчдыг нутгийн иргэд, айл өрхүүдтэй зүй зохистой харьцах, харилцах талаар сумдын Засаг дарга нараар нь арга хэмжээ зохион байгуулуулах | Байнга | Отрын малчид | | Отрын штаб Сумдын Засаг дарга нар |
| 7. | Отор хүлээж авсан зарим суманд эмнэлэг, боловсрол, цагдаа болон төрийн үйлчилгээний зардалд нь дэмжлэг үзүүлж, гэрээ байгуулах ажлыг газар дээр нь зохин байгуулж ажиллах | 11 дүгээр сарын 05-ны дотор | Оторлож буй сумдын тоогоор | Шатахуун томилолтын зардал | И.Доржсүрэн С.Цэдэнбалжир Б.Цэнгэл |
| 8. | Малчдаас авсан болон авахаар төлөвлөсөн бэлчээрийн төлбөр бусад торгууль, хураамжтай холбоотой гомдол саналыг тухай бүрд нь шийдвэрлэж, зохицуулалтын арга хэмжээ авах | Отрын хугацаанд | Гомдол, саналын тоогоор | | Отрын штаб |
| 9. | Отрын малчдын мал тооллогын ажлын зохион байгуулалтыг “Мал тооллогын семинар”-ын үеэр шийдвэрлэх | Мал тооллогын семинараар | Оторлож буй сумдаар | | И.Доржсүрэн Б.Цэнгэл |
| 10. | Ирэх саруудын цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг отрын малчдад хүргүүлж байх | Сар бүр | Отрын малчдын тоогоор | | Б.Цэнгэл Т.Эрдэнэбаяр |
| 11. | Оторчдыг эргэж тойрох, тусламж дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээг отрын малчдад тогтмол хүргэх ажлыг зохион байгуулах | Сар бүр | Отор бүхий сумд | Шатахуун, томилолтын зардал | Отрын штаб |
| 12. | Дундаас доош тарга хүчтэй малаа заазлах арга хэмжээ авах, худалдах борлуулах ажлыг зохион байгуулах, малчдад сурталчлах | 10 дугаар сараас | 19 сумд | | Отрын штаб Сумдын ЗДТГазар |
| 13. | Малчдад туслах сайн санааны аян өрнүүлж, иргэд, ААНэгж, байгууллагыг өргөнөөр оролцуулах | 12 дугаар сард | 19 сумд, Байгууллага, ААНэгж, иргэд | | Отрын штаб |
| 14. | Отроор яваа малчдын малд гарал үүслийн гэрчилгээ олгох, малын эрүүл мэндийн дэвтэрт малд хийсэн тарилга, туулгалт, угаалга, боловсруулалтыг үнэн зөв бичих | 10 дугаар сард багтаан | Отор бүхий сумд | | Сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд |

АЙМГИЙН ОТРЫН ШТАБ

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

# АЙМГИЙН ОТРЫН ШТАБЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.10.22 Арвайхээр сум

| д/д | Хийгдэх ажил | Хугацаа | Тоо хэмжээ | Шаардагдах зардал | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|
| 1. | Отрын малчид орохоос өмнө отор хийх аймаг, сумдын удирдлагуудтай утсаар ярих, уулзах болон ХХААХҮЯам болон аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдэд отрын талаар албан тоотоор мэдээлэл хүргүүлж, оторлох бүс нутаг, оторлох өрх малын тоо, төлбөр хураамжийн талаар тохиролцож, нэгдсэн шийдвэрт хүрэх арга хэмжээ авах | 11 дүгээр сарын 01-ны дотор | Уулзалт, ярилцлага, албан тоотын тоогоор | | И.Доржсүрэн С.Цэдэнбалжир Б.Цэнгэл |
| 2. | Оторлох өрхийн ам бүлд өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эх байгаа эсэх, оторлож байгаа газарт холбогдох утасны дугаар, малын тоог бог бодоор тооцож, оторлож байгаа аймаг, сум, баг, газрын байршлаар схем зураг гаргаж, 14 хоног тутам шинэчилж байх | 11 дүгээр сарын 10-наас | Оторлож буй өрхийн тоогоор | | Б.Цэнгэл Т.Эрдэнэбаяр Сумдын ХАА-тасаг |
| 3. | Отроор малчид нь гадны суманд яваа сумдын болон отор оруулсан гадны сумдын Засаг дарга, ЭМТөвийн дарга, Сургуулийн захирал, цагдаагийн ажилтны утасны дугаарыг авч бүх сумдад хүргүүлж, хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх | 11 дүгээр сард багтаан | Отор бүхий сумд | | И.Доржсүрэн Б.Цэнгэл |
| 4. | Цагдаагийн газар, МЭГазрын мэргэжилтнүүдийг тодорхой удирдамжаар отрын малчид явах замын дагуу пост ажиллуулж, малын гарал үүсэл, малын эрүүл мэндийн дэвтрийн бичилт, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт хийх | 11 дүгээр сард | Шартын даваа, Хөөвөр, Элсэн тасархай орчмын отрын зам дагуу | Шатахуун, томилолтын зардал | И.Доржсүрэн О.Ганбат А.Нямдаваа |
| 5. | Хэрэв отрын нутагт аймгийн мал сүргээс үүсэлтэй халдварт | Тухай бүр | Хамрагдах малчид | | Отрын штаб |

Аймгийн Засаг даргын 2019 оны ..10...
дугаар сарын ..31....ны өдрийн ..А/672...дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОТРЫН ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Штабын дарга: И.Доржсүрэн- Аймгийн Засаг даргын орлогч
Штабын орлогч дарга: С.Цэдэнбалжир –Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд: Г.Баясгалан –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Т.Мөнхдорж –Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Д.Шивааннүрдэв –Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
О.Ганбат –Аймгийн Цагдаагийн газрын дарга
С.Дуламсүрэн –Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга
Ж.Пүрэвсүрэн –Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Ч.Гүнсэнхорол –Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Б.Оюунчимэг – Аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга
А.Нямдаваа – Аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл –Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

-oOo-